



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2023 оны 11 дүгээр
сарын 01-ний өдөр

Дугаар 10

Төрийн ордон,
Улаанбаатар хот

ЗАСГИЙН ГАЗАРТ ЧИГЛЭЛ ӨГӨХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.6 дахь хэсгийг үндэслэн Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооноос санаачилж "Шинжлэх ухааны академийн философийн хүрээлэн", "Монгол Улсын Их сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн философи, шашин судлалын тэнхимтэй" хамтран зохион байгуулсан "Өнөөгийн монголын нийгмийн ёс суртахууны өөрчлөлт, хандлага" сэдэвт хэлэлцүүлгээс төрийн байгууллага, олон нийтэд хандан гаргасан зөвлөмж, уриалгыг үндэслэн дараах арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Засгийн газарт чиглэл болгосугай:

1/Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд нийцүүлэн ёс зүйн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийг боловсронгуй болгох төслийг боловсруулан Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан өргөн мэдүүлэх;

2/Монгол Улсын Засгийн газар хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэн шийдвэр гаргахдаа төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжид заасан зарчим, нийтлэг хэм хэмжээ, шаардлагад нийцүүлж байх;

3/Төрийн өндөр албан тушаалтан хууль тогтоомжид заасан ёс зүйн зөрчил гаргавал өөрийн хүсэлтээр албанаасаа чөлөөлөгдөх, холбогдох байгууллагаар шалгуулдаг байх соёлыг хэвшүүлэхэд Засгийн газрын манлайлал, үүрэг, оролцоог дээшлүүлэх;

4/Иргэн төрийн албанд анх ороход тавих ёс зүйн шаардлагыг өндөрсгөх, ёс зүйн зөрчил гаргаж байсан хунийг төрийн жинхэнэ албанд томилохгүй, албан тушаал дэвшүүлэхгүй байх зарчмыг хатуу мөрдөх;

5/Засгийн газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороог байгуулах, уг дэд хорооны ажлыг мэргэжил, арга зүй, зохион байгуулалтын удирдлагаар ханган, уйл ажиллагааг жигдрүүлэх;

6/Нийгэмд ёс суртахууны эерэг чиг хандлагыг төлөвшүүлэх чиглэлээр ерөнхий боловсролын болон их, дээд сургууль, шинжлэх ухаан, соёл, урлаг, хэвлэл мэдээллийн байгууллага, төрийн бус байгууллагад дэмжлэг үзүүлэх, хамтарч ажиллах;

7/Цахим орчинд ёс суртахууны үнэт зүйлсийг эрхэмлэх хүрээнд нийгмийн ёс суртахууныг дээшлүүлэх, ёс зүйгүй харилцаа, хандлагыг өөрчлөх, олон нийтийн сүлжээнд хуний эрхийг хамгаалах чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, хуулийн этгээдтэй хамтран ажиллах эрх зүйн орчныг бий болгох;

8/Нийгмийн ёс суртахууны түвшин, чиг хандлагын талаар мэргэжлийн байгууллага, эрдэмтдээр суурь судалгаа хийлгэж, түүний үр дүн, санал, зөвлөмжийг төрийн бодлого боловсруулахад тусгах;

9/Шинжлэх ухааны судалгаа, ололтод тулгуурлан ёс зүйн боловсролыг төлөвшүүлэх Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрт "Иргэний ёс зүй" "Ёс зүйн үндэс", их, дээд сургуульд "Мэргэжлийн ёс зүй" хичээлийг заавал судлах сэдэв болгон, сургалтын агуулга, заах арга зүйг шинэчлэн сайжруулах, багш нарыг мэргэшүүлэх, хэвлэмэл болон дижитал сурах бичиг, сургалтын хэрэгслээр хангах ажлыг цогцоор нь шийдэж, ёс зүйн боловсролыг чанарын шинэ шатанд гаргах.

2.Тогтоолын биелэлтийн явцыг Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд багтаан Байнгын хороонд танилцуулахыг Монгол Улсын Ерөнхий сайд (Л.Оюун-Эрдэнэ), Боловсрол, шинжлэх ухааны сайд (Л.Энх-Амгалан), Төрийн албаны зөвлөлийн дарга (Б.Баатарзориг) нарт даалгасугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо (Б.Баттөмөр)-нд даалгасугай.

ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б. БАТТӨМӨР